



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,

И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023.04.06 № 866

таний -ны № -т

БАЯНГОЛ, СҮХБААТАР
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2023 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ УЛС ТӨРИЙН НАМ,
ЭВСЛИЙН УДИРДЛАГА ТАНАА

Хандивын тайлан ирүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 дугаар тушаалаар “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”-ыг баталсан бөгөөд энэхүү зааврын хавсралт МАЯГТ 1, 2-ын дагуу Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайланг нам, эвслээс 2023 оны 4 дүгээр сарын 10-ний өдрийн 17.30 цагаас өмнө Нийслэл дэх Төрийн аудитын газар хүлээн авна.

Энэхүү албан бичгийн хавсралтаар хүргүүлж буй Маягт 1,2-ын дагуу хандивын тайлангаа үнэн зөв, холбогдох мэдээллийг бүрэн тусгасан байдлаар, дүгнэлт гаргуулахад шаардлагатай дараах баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр хуульд заасан хугацааны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар /Соёлын төв өргөө “Г корпус 5 давхар/-т хаяглан битүүмжлэн ирүүлнэ үү. Үүнд:

- Намын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;
- Нам, эвсэлд нэгдэн орсон намуудын хандивын дансны 2022 оны санхүүгийн жилийн эцсийн аудитлагдсан тайлан болон банкны баталгаажуулсан хуулга, банкны тодорхойлолт /данс бүрээр/;
- Нам, эвсэлд нэгдэн орсон намуудын хандивын дансны 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон харилцагч банкны баталгаажуулсан дансны хуулга, банкны тодорхойлолт /данс бүрээр/.

Хандивын тайландаа намын дүрэм, дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан намын гишүүний өгсөн татвар, хандивыг хамруулахгүй бөгөөд түүнчлэн нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайландаа аливаа байдлаар тусгагдаагүй орхигдсон эсхүл мэдээлээгүй хандивыг Нийслэл дэх Төрийн аудитын газар хянан баталгаажуулаагүйд тооцох ба үүсэх үр дагаврыг хариуцахгүй болно.

Нийслэл дэх Төрийн аудитын газар нь хандивын тайланг хянаж, дүгнэлт гаргах явцад нам, эвслээс ирүүлсэн мэдээллийн хүрээнд Төрийн аудитын тухай

хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг баримтлан ажиллана. Хүргүүлсэн маягт болон холбогдох асуудлаар нэмэлт тодруулга, лавлагаа шаардлагатай бол Аудитын удирдлага зохицуулалтын хэлтсийн 31-55-78 дугаарын утсаар холбогдох боломжтой. Хугацаа хоцроосон хандивын тайланг хүлээн авах хуулийн зохицуулалт байхгүй болохыг анхаарна уу.

Хавсралт ~~и~~ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,
дүгнэлт гаргах зөвврүүн хавсралт Маягт 1

Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох нам эвслэлд
“ИРГЭН”-ээс өгсөн хандивын тайлангийн маягт

..... /нам, эвслийн нэр/

Д/Д	Иргэний овог нэр	Хандив өтсөн иргэний мэдээлэл			Хандив өтсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан Банкны нэр	Хандивын дундаж дугаар	Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин хаяг					
Эзлжилт бус нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн 01 дугаар сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон									
1									
2									
3									
4									

Санамж: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар
зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасан иргэн, хуулийн этгээдээс өвсөн хандивт намын дүрэм, дотоод зохион байгуулалтын
үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.

Тамга тэмдэг

ХЯНАСАН:

Албан тушаалт
Овог нэр
Гарын Үсэг

Озноо

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдээр баталгаажуулна.

Нам эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж,
дүгнэлт гарах зааврын хавсралт Маягт 2

Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оропцох нам ЭВСЭЛД
“Хүүлийн ЭТГЭЭД”-ээс өгсөн хандивын Тайлангийн Маягт
..... /нам, эвслийн нэр/

Д/Д	Хүүлийн этгээдийн нэр	Хандив өтсөн хуулийн этгээдийн мэдээлэл					Хандив хулээн авсан			Мөнгөн дүн	Тайлбар
		Регистрийн дугаар	Хаяг, утасны дугаар	Үүстэн байгулагдсан огноо	Үйл акжиллагааны чиглэл	Хуулийн этгээдийн хэлбэр	Отноо Банкны нэр	Дансны дугаар			
1	Зэлжжит бус нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн ёмнөх тайлант жилийн 01 дугаар сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон										
2											
3											
4											

Санамж: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар
зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан чргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотоод зохион
байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй

Тамга тэмдэг

ХЯНАСАН:

Албан тушаал
Овог нэр
Онгоо

Гарын Үсэг

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдээр баталгаажуулна.